148

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 01 сарын 08 өдөр Дугаар 07 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн байгууллагыг
магадлан итгэмжлэх шалгуур
үзүүлэлт батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18, 22 дугаар зүйлийн 22.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо эмчилгээний төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг нэгдүгээр, нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг хоёрдугаар, сум дундын эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг гуравдугаар, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг дөрөвдүгээр, өрхийн эрүүл мэндийн төвийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг тавдугаар, сувиллыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2011 оны "Шалгуур үзүүлэлт батлах тухай" 395 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Н.УДВАЛ

080010

197

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 01 сарын 08 өдрийн
07 тоот тушаалын 4 дүгээр
хавсралт

СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үнэлгээ өгөх чиглэл	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ	
			Байгууллага	Шинжээч
БҮЛЭГ 1. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт				
1.	Байгууллагын удирдлага, манлайлал	1.1 Стандартын дагуу тасаг, нэгжийг зохион байгуулсан байх		
		1.2 Эрүүл мэндийн ажилтнууд орон тоогоор бүрэн ажилладаг байх		
		1.3 Мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх стандарт, удирдамжаар хангагдсан, сургалт хийдэг байх		
		1.4 Байгууллага нь судалгаа, харьцуулсан үнэлгээнүүдэд үндэслэсэн хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй, хэрэгжүүлсэн байх		
		1.5 Болзошгүй гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх төлөвлөгөөтэй, жил бүр тодотгол хийдэг байх		
		1.6 Ажлын байрны тодорхойлолтыг ажилтан бүрээр гарган баталгаажуулж, ажилтнуудыг байршуулсан байх		
		1.7 Эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, ажлын гүйцэтгэлд жил бүр үнэлгээ өгдөг, урамшуулал, хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн байх		
		1.8 Дотоод хяналтын үйл ажиллагаа тогтмолжсон байх		
		1.9 Санхүүгийн хяналт, шалгалтад хамрагдсан, зөрчилгүй ажилласан байх		
2.	Хүний нөөцийн хөгжил	2.1 Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, /төлөвлөгөө/-тэй, баталгаажуулж, хэрэгжүүлсэн байх		
		2.2 Мэргэжил олгож дээшлүүлсэн эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлсэн байх		
		2.3 Эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургалтанд хамруулдаг байх		
		2.4 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг байх		

3.	Тусламж үйлчилгээний чанарын удирдлага	3.1 Чанарын алба/багтай, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх	
		3.2 Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлж, чанарын үзүүлэлтийг гаргаж мөрдүүлсэн, түүнд нь ахиц гарсан байх	
		3.3 Эрүүл мэндийн ажилтнууд чанарын сургалтад хамрагдсан байх	
		3.4 Чанар сайжруулах дэвшилтэт аргуудыг нэвтрүүлсэн, үр дүнг тооцсон байх	
		3.5 Байгууллага нь ажилтан бүрээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлдэг байх	
		3.6 Үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлдэг байх	
		3.7 Үйлчлүүлэгчдийн санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг байх	
4.	Мэдээллийн удирдлага	4.1 Байгууллага нь үйл ажиллагааны үзүүлэлтүүд болон хүний нөөц, санхүү, багаж тоног төхөөрөмж, эмийн мэдээллээр сүүлийн 5 жилээс доошгүй хугацааны мэдээний санг үүсгэж, тогтмол баяжуулдаг байх	
		4.2 Байгууллага нь гадаад, дотоод сүлжээнд холбогдсон, үйл ажиллагаа нь тогтмолжсон, ажилтнууд мэдээллийн сүлжээг ашигладаг байх	
5.	Аюулгүй байдал, эрсдлийн удирдлага	5.1 Аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын багтай, төлөвлөгөөтэй ажилладаг байх	
		5.2 Байгууллага нь аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээг тогтмол хийдэг байх	
		5.3 Алдаа зөрчлийг бүртгэж, мэдээлдэг, хариу арга хэмжээ авдаг байх	
		5.4 Эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьдаг байх	
6.	Байгууллагын соёл, ил тод байдал	6.1 Байгууллагын соёлыг төлөвшүүлсэн байх	
		6.2 Удирдлагын үйл ажиллагаа, хүний нөөцийн,төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж ажилладаг байх	
БҮЛЭГ 2. Тусламж үйлчилгээний технологийн мөрдөлт			
а. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ			
7.	Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилт	7.1 Байгууллагад хэрэгжүүлж байгаа нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр тус бүрээр төлөвлөгөөтэй ажилладаг байх	
		7.2 Хөтөлбөр бүрийн шалгуур үзүүлэлтийг тооцсон судалгаа хийж, дүгнэлт гаргаж ажилладаг байх	
		7.3 Хөтөлбөр бүрийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийж, асуудлыг шийдвэрлэсэн байх	
8.	Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг	8.1 Өөрийн харъяаллын хүн амын дунд халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, үнэлэх, тандах судалгаа хийж, өвчин гарсан тохиолдолд хариу арга	

	тандах, судлах, хянах үйл ажиллагаа	хэмжээ авсан байх	
		8.2 Хүн амын дунд халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, үнэлэх, тандах судалгаа хийдэг байх	
		8.3 Халдварт бус өвчний үзлэгийг зохион байгуулж, үр дүнг тооцож, арга хэмжээ авсан байх	
9.	Эрүүл мэндийг дэмжих хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	9.1 Эрүүл зан үйл төлөвшүүлэх /архи, тамхи, мансууруулах бодисыг хэрэглэх буруу зан үйлийг өөрчлөх, зөв хооллолт,дасгал хөдөлгөөн хийх/ ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх	
		9.2 Бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийдэг байх	
		9.3 Гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг олгох, жирэмслэлтээс сэргийлэх аргад сургах ажлыг зохион байгуулсан байх	
		9.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон асран хамгаалагчдад дадал эзэмшүүлэх ажлыг зохион байгуулсан байх	
		9.5 Албан байгууллага, нэгжид эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэхэд арга зүйгээр хангаж хамтран ажилласан байх	
		9.6 Эрүүл мэндийг дэмжигч байгууллага,хамт олон, сум, хороо, баг, сургууль, ажлын байр, гэр бүлийн тоог жил бүр нэмэгдүүлсэн байх	
		9.7 Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих Үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлсэн байх/Ажилтнуудад халуун хоол, буцалсан, цэвэр усаар үйчлэх, идэвхтэй хөдөлгөөн хийх,архи, тамхигүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ/	
10.	Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох	10.1 Үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр /төлөвлөгөө/-тэй, сургалт явуулдаг байх	
		10.2 Үйлчлүүлэгч эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл авах нөхцөлөөр хангагдсан байх \ мэдээллийн самбар, теливиз \	
		10.3 Үйлчүүлэгчид тухайн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгдөг байх	
		10.4 Хүүхдийн дунд амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах талаар мэдээлэл сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байх	
		10.5 Осол гэмтлээ сурьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байх	
		10.6 Ye тэнгийн сургагч багш, сайн дурын идэвхтэний тоо жил бүр нэмэгдэж, үйл ажиллагаа тогтмолжсон байх	
11.	Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх	11.1 Хүн амын бие бялдрын түвшинг тогтоож, дасгал хөдөлгөөнд хамруулсан хувь жил бүр нэмэгдсэн байх	

	тусламж үйлчилгээ	11.2 Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх өрөөг стандартын дагуу зохион байгуулж, тоног төхөөрөмжөөр хангасан байх	
б.Амбулаторын тусламж үйлчилгээ			
12.	Үзлэг, оношилгоо, эмчилгээ	12.1 Тусламж үйлчилгээний багцын жагсаалтад заагдсан өвчин эмгэгийн үзлэг, оношилгоог стандарт, удирдамжийн дагуу бүрэн хийдэг байх	
		12.2 Үзлэг шинжилгээг үндэслэн оношийг зөв, цаг хугацаанд нь бүрэн тогтоодог байх	
		12.3 Үзүүлж буй тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийн жагсаалт гаргаж, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гарын авлагаар хангасан байх	
		12.4 Эмийг зохистой хэрэглэж, антибиотикийг зөв сонгож, эмчилгээг хийсэн байх ба судалгаатай байх	
13.	Лавлагаа, мэдээллийн үйлчилгээ	13.1 Хүлээлгийн танхимд лавлагаа мэдээллийн цэг ажиллуулж, үйлчлүүлэгчид болон гэр бүлийнхнийг мэдээллээр хангадаг байх	
		13.2 Үйлчлүүлэгчдийг угтан авах, үдэн гаргах үйлчилгээг нэвтрүүлсэн байх	
		13.3 Хүлээлгийн танхимд үйлчлүүлэгчдэд ая тухтай орчин бүрдүүлж, хүрэлцэхүйц суух сандал, мэдээллийн самбарууд байрлуулсан байх	
14.	Нөхөн үржихүйн эрүүл мэнд	14.1 Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэлтэй, жил бүр баяжилт хийж, үзлэг зохион байгуулсан байх	
		14.2 Жирэмсэн эмэгтэйчүүдийг эрт хугацаанд нь хяналтанд авч үзлэг, шинжилгээнд хамруулдаг байх	
		14.3 Эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг эрт оношилж, шаардлагатай арга хэмжээг авсан байх	
		14.4 Эмэгтэйчүүдийг хөхөө шалгах аргад сургасан, бүртгэлтэй байх	
		14.5 Эхчүүдэд дан хөхөөр хооллох талаар мэдээлэл,сургалт сурталчилгааг тогтмол явуулдаг байх	
		14.6 Ая тухтай нөхцөлийг хангасан эхчүүдийн амрах байртай, үйлчлэх хүрээний эхчүүдийг амраасан хувь жил бүр нэмэгдсэн байх	
15.	Хүүхдийн эрүүл мэнд	15.1 Хүүхдийн өвчний цогц менежментийг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх	
		15.2 Хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж насны бүлгээр хянах графиктай, мөрдөж ажилладаг байх	
		15.3 0-1 насны хүүхдийг 100% гэрийн идэвхтэй эргэлтээр үзэж тусламж үзүүлсэн байх	
		15.4 Хамарвал зохих хүүхдийг товлолт дархлаажуулалтад бүрэн хамруулсан байх	

16.	Халдварт өвчнөөс сэргийлэх	16.1 Халдварт өвчнийг эрт илрүүлэх үзлэгийг жил бүр хийж, бүртгэл хөтөлсөн байх	
		16.2 Хяналтад авбал зохих үйлчлүүлэгчийг бүрэн авч, эмчилгээ, эрүүлжилтийн үр дүнг тооцдог байх	
		16.3 Халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байх	
17.	Хавдраас сэргийлэх	17.1 Зонхилон тохиолдох хавдрын эрсдэлт хүчин зүйлүүд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан, үр дүнг тооцсон байх	
		17.2 Умайн хүзүү, хөхний өмөнг эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулж, наацын шинжилгээг хийж, онош тодруулах эмэгтэйчүүдийг аймаг, дүүргийн эмнэлэг рүү бататгах шинжилгээнд илгээдэг байх	
18.	Ахмад настан, эмзэг болон ядуу бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	18.1 Ахмад настан, эмзэг бүлгийн үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, онош тодруулах, эмчлэх арга хэмжээг авч, үр дүнг тооцдог байх	
		18.2 Ахмад настан, эмзэг болон ядуу бүлгийн иргэдийг тодорхой товлосон хугацаа, чиглэлүүдээр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг хийсэн байх	
		18.3 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад шаардлагатай үйлчлүүлэгчдэд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлдэг байх	
19.	Нүүр амны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	19.1 Хүн амд шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг жил бүр хийж, эрүүлжүүлэх арга хэмжээ авсан байх	
		19.2 Хүүхдийн шүдний кариес өвчнийг эмчлэн эрүүлжүүлж үр дүнг тооцсон байх	
20.	Нүдний тусламж үйлчилгээ	20.1 Нүдний тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай багаж, хэрэгслээр хангасан байх	
		20.2 Сохролоос \нүдний даралт ихсэх өвчин\ урьдчилан сэргийлэх ажил хийсэн байх	
		20.3 Мэргэжлийн эмч нартай хамтран өвчтэй хүмүүсийг хяналтанд авч, эрүүлжүүлэх арга хэмжээ авсан байх	
21.	Чих хамар хоолойн тусламж үйлчилгээ	21.1 Тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай багаж, төхөөрөмжөөр хангасан байх	
		21.2 Хүн амыг дүлийрлээс сэргийлэх үзлэг хийж, шаардлагатай үйлчлүүлэгчийг протезийн үйлчилгээнд хамруулсан байх	
		21.3 Хүн амын дунд гүйлсэн булчирхайн болон дунд чихний үрэвслийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг жил бүр хийж, үр дүнг тооцсон байх	
22.	Сэтгэцийн эрүүл мэнд	22.1 Сэтгэцийн эмгэгтэй үйлчлүүлэгчид стандарт, удирдамжийн дагуу тусламж үйлчилгээ үзүүлдэг байх	

		22.2 Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст нийгэм хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээ үзүүлдэг байх	
		22.3 Сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг байх	
23.	Сэргээн засах тусламж үйлчилгээ	23.1 Сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх нэр төрлийн жагсаалт, технологитой байх	
		23.2 Сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах багаж, тоног төхөөрөмжтэй байх	
		23.3 Сэргээх засах эмчилгээнд архаг өвчтөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулдаг байх	
		23.4 Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ /бариа засал, бумба, цахилгаан төөнө, зүү гэх мэт/ -г стандарт, удирдамжийн дагуу үзүүлдэг байх	
в. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ			
24.	Хүлээн авах, яаралтай тусламж үйлчилгээ	24.1 Үйлчлүүлэгчийг хүлээн авах журам боловсруулж, мөрдөж ажилласан байх	
		24.2 Үйлчлүүлэгчийг хүлээн авч бүртгэх, үзлэг хийх, тусламж үзүүлэх өрөөг стандартын дагуу зохион байгуулсан байх	
		24.3 Яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх	
		24.4 Эрэмбэлэн ангилах зарчмын дагуу үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгч, тусламж үйлчилгээг шуурхай үзүүлдэг байх	
		24.5 Эмнэлгийн мэргэжилтнүүд амилуулах суурь тусламж үзүүлэх ур чадвар эзэмшсэн байх	
25.	Тарианы өрөөний үйл ажиллагаа	25.1 Тарианы зориулалтын өрөөтэй, эм тариа, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх	
		25.2 Тариа, ажилбарыг хийх технологи аргачлалтай, түүнийг мөрддөг байх	
26.	Өвчний түүхийн хөтлөлт	26.1 Өвчний түүхийг бүрэн хөтөлсөн байх /Тухайн үед эмчлэгдэж байгаа болон эмчлэгдээд гарсан өвчтөний түүхээс түүвэрчлэн үзнэ/	
		26.2 Лабораторийн болон бусад шинжилгээг оношилгоо, эмчилгээний үндэслэл болгодог байх	
27.	Эмч нарын хамтарсан үзлэг	27.1 Эмч нарын хамтарсан үзлэг хийдэг байх	
		27.2 Төрөлжсөн мэргэжлийн эмч нараас зөвлөгөө авч хамтран ажилладаг байх	
28.	Түргэн тусламжийн үйлчилгээ	28.1 Түргэн тусламжийн дуудлаганд явах хуваарь гаргаж, баталгаажуулдаг байх	
		28.2 Дуудлага хүлээн авсан, дуудлаганд гарсан хугацааг бүртгэж, тусламжийг шуурхай үзүүлдэг байх	
		28.3 Тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, багаж хэрэгсэл бүрэн, нөхөн хангалтыг хийдэг, бүртгэлтэй байх	

		28.4 Түргэн тусламжийн автомашины бэлэн байдлыг хангасан байх	
29.	Эх барихын тусламж үйлчилгээ	29.1 Төрлөг удирдах үйл ажиллагааг стандарт, удирдамжийн дагуу хийдэг байх	
		29.2 Төрөх өрөөнд төрлөг явуулахад шаардагдах эм тариа, багаж хэрэгслийн бэлэн байдлыг бүрэн хангасан байх	
		29.3 Нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл, материалаар бүрэн хангагдсан, шаардлагатай багажийн хангалтын нөөцтэй байх	
		29.4 Төрсний дараа эх, нярайд тавих хяналтыг стандарт удирдамжийн дагуу үзүүлдэг байх	
30.	Сувилахуйн тусламж үйлчилгээ	30.1 Сувилахуйн тусламжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, удирдамжтай байх	
		30.2 Сувилахуйн тусламж үйлчилгээг стандарт удирдамжийн дагуу үзүүлдэг байх	
		30.3 Анхан шатны бүртгэл маягтыг журмын дагуу хөтөлдөг байх	
		30.4 Сувилахуйн тусламж үйлчилгээнд хяналт тавьж, үр дүнг тооцдог байх	
31.	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ	31.1 Тусламж үйлчилгээг стандартын дагуу үзүүлдэг байх	
		31.2 Хөнгөвчлөх эмчилгээг гэрээр үзүүлдэг байх	
32.	Эмчилгээний хоолны үйлчилгээ	32.1 Үйлчлүүлэгчдэд зориулсан эмчилгээний хоолны технологи, цэс боловсруулж батлуулсан байх	
		32.2 Хоолыг технологийн дагуу бэлтгэж, илчлэг нормыг тооцдог байх	
		32.3 Хүнд өвчтөнийг хооллоход зориулсан хэрэгсэлтэй байх	
33.	Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ	33.1 Цус, цусан бүтээгдэхүүн (ЦЦБ) хэрэглэхтэй холбоотой удирдамж, баримт бичгээр хангасан байх	
		33.2 ЦЦБ сэлбэхэд шаардлагатай багаж, хэрэгсэл (цусны бүлэг тодорхойлох таваг хэрэгсэл, цус цуглуулах хүүдий, сэлбэх зориулалтын систем, тээвэрлэх зориулалтын сав, хадгалах хөргөгч, хөлдөөгч)-ээр хангагдсан байх	
		33.3 Эмч мэргэжилтэнг сургалтад хамруулсан байх	
		33.4 Цусны АВО бүлэг бүрээс 4 - 5 донортой, бүртгэлтэй байх	
34.	Лабораторийн болон бусад шинжилгээ	34.1 Тусламж үйлчилгээний багцад заагдсан шинжилгээнүүдийг бүрэн хийж, хяналтанд хамрагдсан байх	
		34.2 Түргэвчилсэн оношлууараар хийх шинжилгээг бүрэн хийдэг байх	
		34.3 Лабораторийн шинжилгээний стандарт, удирдамжаар хангасан, мөрдөж ажилладаг байх	

		34.4 Лабораторийн тоног, төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангаж ажилладаг байх	
		34.5 Лабораторит шаардлагатай урвалж, бодис, оношлуураар бүрэн хангагдсан, нөөцтэй байх	
		34.6 Урвалж, бодис, оношлуурын хадгалалт, шинжилгээнд хэрэглэх үеийн аюулгүй ажиллагааг хангасан байх	
		34.7 Чанд авиа, зүрхний цахилгаан бичлэг зэрэг бусад шаардлагатай шинжилгээг хийдэг байх	
35.	Эмгэг судлалын шинжилгээ	35.1 Цогцос хадгалах, шинжлэх өрөө тасалгааг стандартын дагуу зохион байгуулсан байх	
		35.2 Цогцосыг ар гэрт хүлээлгэн өгөх журамтай мөрдөж ажилладаг байх	
		35.3 Эмгэг судлалын шинжилгээг журмын дагуу тохиолдол бүрт хийлгэдэг байх	
36.	Эмнэлгийн эмийн сангийн үйл ажиллагаа	36.1 Эмийн санг стандартын дагуу зохион байгуулж, мэргэжилтнээр хангасан байх	
		36.2 Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалттай эмээр бүрэн хангасан, нөөцийн эмийн өрөөтэй, эмийг зөв хадгалсан байх	
		36.3 Хадгалалтын онцгой нөхцөл шаарддаг эмүүдийг зөв хадгалдаг байх	
37.	Эмийн зохистой хэрэглээ	37.1 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байх	
		37.2 Эмийн гаж нөлөөний бүртгэл судалгаа хийж, арга хэмжээ авдаг байх	
38.	Өвчтөнг эмнэлэг хооронд шилжүүлэх, эмнэлгээс гаргах, хяналт тавих	38.1 Үйлчлүүлэгчийг дээд шатлалын эмнэлэгт илгээсэн бүртгэл хөтөлж, эргэж мэдээлэх ажил тогтмолжсон байх	
		38.2 Өвчтөнийг эмнэлгээс гарахад нь эмнэлгийн хуудас олгож, картанд бичилт хийж, зөвлөгөө өгдөг байх	
		38.3 Эмнэлгээс гарсан өвчтөнийг эргэн хянадаг, картыг тогтмол хөтөлдөг байх	
БҮЛЭГ 3. Эрүүл ахуйн нөхцөл, халдварын сэргийлэлт, хяналт, техникийн үйлчилгээ			
39.	Барилга, байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлага	39.1 Эрүүл ахуйн шаардлагын дагуу зөв зохион байгуулагдсан зориулалтын байртай, хэвтүүлэн эмчлэх болон үзлэгийн хэсэг нь тусдаа байх	
		39.2 Гадна талбай орчны стандартын шаардлага хангасан тохижилттой байх	
		39.3 Бүх өрөө байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, агааржуулалттай, мэс засал, лаборатори, ариутгал, гал тогоо зэрэг зарим өрөө нэмэлт агааржуулах системтэй байх	
40.	Халдвараас сэргийлэх үйл ажиллагаа	40.1 Халдварын сэргийлэлт, хяналт (ХСХ)-ын хөтөлбөр, төлөвлөгөөтэй, хэрэгжүүлж ажилладаг байх	

		40.2 Үйл ажиллагааны онцлогт тохирсон ХСХ-ын журамтай, түүнийг эмнэлгийн ажилтнуудад танилцуулж мөрдөж ажилладаг байх	
		40.3 ХСХ-ыг сайжруулах сайн туршлага, шинэ санааг нэвтрүүлж хэрэгжүүлдэг байх	
		40.4 ЭТҮХХ-ын үйл ажиллагааг тогтсон хугацаанд хянаж, дүгнэдэг, үр дүн гарсан байх	
		40.5 Өрөө бүрт хэвийн ажиллагаатай, ажилбарын өрөөнүүд мэдрэгчтэй болон тохой, хөлөөр ажилладаг угаалтууртай байх	
		40.6 Нянгийн эсрэг шингэн саван, спиртэнд суурьтай халдваргүйжүүлэх бодис, гарын цаасан алчуураар хангасан байх	
41.	ЭТҮХХ-ын тандалт, хариу арга хэмжээ	41.1 Тандалт хийж эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-ыг илрүүлсэн байх	
		41.2 ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг зохих журмын дагуу мэдээлж, хариу арга хэмжээг цаг алдалгүй авдаг байх	
		41.3 Халдварын эрсдэл өндөртэй ажилбаруудад тандалт хийж шалгуур хуудас хөтөлдөг байх	
42.	Ажилтны эрүүл мэндийг хамгаалах	42.1 Ажилтнуудыг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1-2 удаа зохион байгуулалттайгаар хамруулж, эмчлэх, эрүүлжүүлэх арга хэмжээ авдаг байх	
		42.2 Ажилтнуудын амрах, бие бялдрыг чийрэгжүүлэх боломж нөхцлөөр хангасан байх	
		42.3 Шинээр ажилд орж буй иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан байх	
		42.4 Халдвар авах эрсдэлд хүчин зүйлд өртөлтийг бүртгэж, халдвараас сэргийлэх арга хэмжээг авсан байх	
		42.5 Тасаг, нэгж бүр өртөлтийн дараах сэргийлэлтийн иж бүрдлээр хангагдсан байх	
		42.6 Эрүүл мэндийн ажилтныг дүрэмт болон хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр хангаж, нөөцийг бүрдүүлсэн байх	
		42.7 Цусаар дамжих халдвартай эмнэлгийн ажилтны эрүүл мэндэд хяналт тавьж, ажил үүргээ гүйцэтгэх үед халдвар дамжуулах эрсдлээс сэргийлж заавар, зөвлөмж өгдөг байх	
43.	Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж, мэрэгчгүйтгэл	43.1 Бохир, цэвэр, ариун хэсгээр тусгаарласан ариутгалын тасаг, хэсэгтэй, ариутгалын журамтай, түүнийг мөрддөг байх	
		43.2 Ариутгалын тоног төхөөрөмжөөр хангагдсан, баталгаажилт хийлгэсэн байх	
		43.3 Ариутгалын үйл ажиллагаанд хяналт тавьж, баталгаажуулдаг байх	

		43.4 Улсын бүртгэлд бүртгэгдсэн, зөвшөөрөл, дүгнэлттэй чанарын шаардлага хангасан халдваргүйтгэлийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэдэг байх	
		43.5 Ариутгалын үйл ажиллагаанд хөтлөгддөг анхан шатны маягтууд бүрэн хөтлөгдсөн байх	
		43.6 Ариун материалыг зөв хадгалж хэрэглэдэг байх	
		43.7 Зөөлөн эдлэлийг халдваргүйжүүлдэг байх	
		43.8 Шавж, мэрэгч устгал хийлгэдэг байх	
44.	Хог хаягдлын менежемент	44.1 Хог хаягдлыг зохих журмын дагуу ангилан ялгаж цуглуулдаг байх	
		44.2 Тээвэрлэх сав, тэргэнцэртэй, зөөвөрлөх маршрут, цагийг тогтоосон байх	
		44.3 Эрүүл ахуйн шаардлага хангасан түр хадгалах байртай, жин, тавиур зэрэг шаардлагатай хэрэгслээр хангагдсан байх	
		44.4 Устгалыг зөвшөөрөл бүхий байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлдэг байх эсвэл байгаль орчинд халгүй аргаар, зохих журмын дагуу устгадаг байх	
		44.5 Хог хаягдлын таних тэмдэгтэй зориулалтын уут, саваар хангасан байх	
		44.6 Эмнэлгээс гарч буй хог хаягдлын байдалд бүртгэл судалгаа хийж, бууруулах, менежментийг сайжруулах арга хэмжээ авдаг байх	
		44.7 Хог хаягдлын байдлыг сар бүр нэгтгэн дүгнэж, мэдээлдэг байх	
45.	Угаалга, цэвэрлэгээ	45.1 Тусдаа угаалгын газартай, урсгал нь зөв байх	
		45.2 Ангилан ялгаж угаах тоног төхөөрөмж, тээвэрлэх уут, сав, хадгалах тавиур, шүүгээтэй байх	
		45.3 Цагаан хэрэгсэл халдваргүйжүүлэх болон угаах зориулалтын бодисоор хангагдсан байх	
		45.4 Байгууллагын орчныг эрсдлийн бүсээр ангилан, таних тэмдэгжүүлэн цэвэрлэгээний хуваарьтай, мөрдөж ажилладаг, хяналт тавьдаг байх	
		45.5 Цэвэрлэгээний материал бүхий тэргэнцэр, иж бүрдэлтэй, халдваргүйжүүлж хэрэглэдэг байх	
		45.6 Цэвэрлэгээний материалыг хадгалах цэгтэй байх	
46.	Тусгаарлан сэргийлэлт	46.1 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах төлөвлөгөө, бэлэн байдлыг хангасан байх	
		46.2 Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчний үед хэрэглэгдэх тусгаарлах өрөөтэй байх	

		46.3 Тусгаарлах өрөө нь хувцас, багаж материал, эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан, нөөцтэй байх	
		46.4 Хамгаалах хувцас хэрэгслийг эрүүл мэндийн ажилтнууд зөв өмсөж, тайлж чаддаг байх	
		46.5 Тасаг нэгжүүдэд халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлах нөхцлийг хангасан байх	
47.	Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлага, халдварын эсрэг дэглэм	47.1 Эрүүл ахуйн шаардлага хангасан агааржуулалт, гэрэлтүүлэгтэй, зөв зохион байгуулагдсан гал тогоотой байх	
		47.2 Хоол бэлтгэх, үйлдвэрлэх, хөргөх, хоолны хэрэгслийг угааж, хатаах багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх	
		47.3 Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд материал нь чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын дүгнэлттэй, баталгаажсан байх	
		47.4 Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангаж хадгалах нөхцлийг бүрдүүлсэн байх	
		47.5 Гал тогооны ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээг хийлгэсэн байх	
		47.6 Хоолны дээж авч, хадгалалтын хугацааг мөрддөг, устгалын бүртгэлтэй байх	
48.	Үйлчлүүлэгчдэд зориулсан өвөрмөц шаардлага	48.1 Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тоноглосон угаалтуур, суултууртай, байх	
		48.2 Эрүүл ахуйн шаардлага хангасан матрац, цагаан хэрэгслээр хангасан байх	
		48.3 Үйлчлүүлэгчдэд зориулсан угаалгын үйлчилгээ нэвтрүүлсэн байх	
49.	Багаж, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	49.1 Багаж, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт, цаг ашиглалтын дэвтэр тогтмол хөтөлдөг байх	
		49.2 Шаардлагатай тоног төхөөрөмжинд баталгаажуулалт хийгдсэн байх	
		49.3 Тоног төхөөрөмж бүрийг газардуулгын системд холбож, аюулгүй ажиллагааг хангаж ажилласан байх	
		49.4 Цахилгаан, дулаан, усан хангамжийн хэвийн ажиллагааг хангах талаар мэргэжлийн байгууллагуудтай гэрээтэй ажилладаг байх	
		49.4 Байгууллагын хүчин чадалд тохирсон цахилгааны нөөц үүсгүүртэй байх	
		49.5 Даралтат сав, хийн баллоны аюулгүй ажиллах дүрэм, журамтай, мөрддөг байх	
50.	Галын аюулгүй ажиллагаа	50.1 Галын аюулгүй байдал, гал унтраах техник, хэрэгслийг ашиглах талаар ажилтнуудыг сургалтад хамруулсан байх	
		50.2 Гал гарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах тусгай тэмдэг бүхий гарц, схем зураглалтай байх	

		50.3 Галын аюулын үед сэрэмжлүүлэх дуудлагын болон дохиоллын хэрэгслээр хангасан байх.	
		50.4 Галын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байх	
		50.5 Галын хорыг шаардлагатай өрөө, цэгт зохих журмын дагуу байрлуулж, тус бүрт нь техник ашиглалтын паспорт хөтөлсөн, ашигласан болон цэнэглэсэн бүртгэл, тэмдэглэл хөтөлсөн, мэргэжлийн байгууллагаар цэнэглүүлсэн байх	

Үнэлгээ:

Шалгуур үзүүлэлтийг 10, 50, 0 оноогоор үнэлнэ.

- Үзүүлэлт бүрийг хангасан бол тус бүрд 100 оноо өгөх ба онооны нийлбэрээр үнэлнэ.
- Үзүүлэлтийг бүрэн хангаагүй бол 50 оноогоор үнэлнэ.
- Үзүүлэлтийг хангаагүй бол 0 оноогоор үнэлнэ